

**ХҮМҮҮНЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ
ТАЙЛАН**

Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тооцлоо.

Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хууль батлагдсанаар төрд тодорхой хэмжээний зардал нэмэгдэнэ. Тооцоонд нэмэлт зардлыг санхүүжүүлж болох хувилбар, арга замыг толорхойлохын зорьсон болно.

Зардлыг тооцохдоо хууль батлагдсанаар байгууллагын хүлээх үүрэгт орж буй өөрчлөлтийг тооцож нэмэгдэж буй үйл ажиллагаатай холбогдон гарах зардлын санхүүжилт,

Хүний нөөцтэй холбогдон гарах зардлын санхүүжилт,,

Зар сурталчилгаа, гарын авлага, ном хэвлэл, сургалтын бусад үйл ажиллагаатай холбогдон гарах зардлын тооцоо гэсэн хэлбэрээр гаргасан болно.

1. Сургууль, цэцэрлэг, их дээд сургууль зэрэг сургалтын байгууллагуудын монгол ахуй, ёс заншил зэрэг сэтгэлийн боловсрол, төлөвшил олгоход чиглэсэн сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухайн байгууллагын хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт оруулах замаар төсвийн урсгал зардлаас санхүүжүүлэх боломжтой гэж тооцов.

2. Хүмүүнлэг боловсрол олгох багш, сургагч нарын цалин хөлс, түүнтэй адилтгах бусад зардал, багш, сургагч нарыг бэлтгэх, давтан сургахтай холбоотой зардлыг боловсролын асуудал хариуцсан сайдын тухайн жилийн багцаас гаргах боломжтой.

Харин хүмүүнлэг боловсрол олгохтой хобоотой үйл ажиллагааг зохицуулах, удирдан чиглүүлэх, бодлого, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий зохицуулах зөвлөлийн зардалд 35.3 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоо хийв.

Хүмүүнлэг боловсрол олгох үйл ажиллагааг сурталчлах, төлөвшил сайтай иргэн, гэр бүл, хамт олныг алдаршуулах зэрэг сурталчилгааныарга хэмжээнд 141.0 сая төгрөг зарцуулах тооцоо гарч байна.

Хүмүүнлэг боловсрол олгох гарын авлага, ном товхимол хэвлүүлэх, үзүүлэн таниулах материал бэлтгэхтэй холбогдон 80.0 сая төгрөгийн зардал гарна гэсэн тооцоог хийв.

	Үзүүлэлт, зардлын агуулга	Дүн /төгрөгөөр/
--	---------------------------	--------------------

1	Зохицуулах зөвлөл 21 гишүүнтэй	Улиралд 1 удаа 420,000.0 төгрөгийн урамшуулал олгох	35,280,000.0
2	Хүмүүнлэг боловсролын сурталчилгаа	Телевизийн сурталчилгаа сард 10 минут 6 сарын хугацаанд 1 минут х 350000 төгрөг	21,000,000.0
		Мэргэжлийн хүнтэй ярилцлага хийх /телевизийн/ улиралд 1 удаа 30 минут /1 минут х 1,000,00.0 төгрөг/	120,000,000.0
3	Гарын авлага, ном товхимол хэвлүүлэх, үзүүлэн таниулах материал бэлтгэх	Гарын авлага 15000 ширхэг х 2000 төгрөг Үзүүлэн таниулах материал 2000 ширхэг х 25000 төгрөг	80,000,000.0
4	Хүмүүнлэг боловсрол олгох багш, сургагч нарын цалин хөлс, түүнтэй адилтгах бусад зардал	БСШУС-ын сайдын багцын тухайн жилийн төсвийн урсгалд зардалд багтаах	
5	Насанд хүрэгчдэд хүмүүнлэг боловсролыг олгох сургалт зохион байгуулах		
6	Материал техник хэрэгслээр хангах		
7	Багш, сургагч нарыг бэлтгэх, давтан сургахтай холбоотой зардал		
8	Бусад зардал		
БҮГД			256,280,000.0

Тайлбар: Телевизийн зар сурталчилгаа болон ярилцлага хийх үнэ тарифыг хувийн арилжааны телевизийн жишиг үнээр тооцсон болно.


Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн нийт зардалд 256,280,000.0 төгрөг улсын төсвөөс гарахаар байна.

--- оОо ---

Архивлагдсан

☐ (/my/login)САНАЛ
АСУУЛГА

ХҮМҮҮНЛЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ



Төслийн файлыг татах (/files/87143)

Share (0) Tweet

ТӨСЛИЙН ХАВСРАЛТУУД

1. Үзэл баримтлал

ТӨСӨЛ САНААЧЛАГЧИД

БАТ-ЭРДЭНЭ
БАДМААНЫМБУУГИЙН

(/projects?user=baterdeneb)

дагасан (0) үзсэн (159) санал (0) (/projects/10738#commentList)

Нийтэлсэн : Хэлэлцүүлгийн Хөтөч (/projects?user=admin) Огноо : 2019-12-04

ЕРӨНХИЙ

ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТААР

Энэ ангилалд одоогоор санал алга байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналаа өгнө үү?

☐ ДЭМЖИНЭ 78%☐ ДЭМЖИХГҮЙ 17%☐ МЭДЭХГҮЙ 4%

Санал өгөх

ИДЭВХИТЭЙ ЭРЭЛТТЭЙ

> Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл (/projects/612)

> Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай /Улсын Их Хурлын гишүүн Л.Энхболд нарын гишүүд өргөн мэдүүлсэн/ (/projects/532)

> Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн төсөл соёрхон батлах тухай (/projects/619)

> Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга (/projects/62)

> Цагдаагийн албаны тухай (/projects/68)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар



НҮБ-ын Ардчилалын сангийн санхүүжилтээр Идеа Дэвэлопмент ХХК хөгжүүлэв. (http://www.ideadevelopment.mn)